



Монголын Эмэгтэйчүүдийн Сан

2002 он



Монголын Эмэгтэйчүүдийн Сан 2002 он

*Санхүүжүүлэгч дараах байгууллагуудад
талархал илэрхийлж амжлын
амжилт хүсье.*

Дэлхийн эмэгтэйчүүдийн сан

Нидерландын Мама Каш Сан

Соросын сан

НҮБ-ын Сайн дурын байгууллага

Пагаан сүүгээрээ хорвоог тэжээсэн
Цайлган сэтгэлт монгол бүсгүйчүүд
Гэгээн хорвоогийн жаргал зовлонг
Гэргийн заяатай хамт туулдаг

Эрхт төр, эх орныхоо төлөө
Эр хүн шиг бүсээ чангалдаг
Үрийн бүүвэй аялж суухдаа ч
Ухаанаа уралдуулж
Улс гэрээ тохинуулж байдаг...

Ц. Түмэнбаяр

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Монгол орон 70 гаруй жил оршин тогтносон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий социализмаас зах зээлийн эдийн засагтай арчигдсан нийгэм рүү шилжих шилжилтийн үеийг туула байна.

Монголын өнөөгийн хүн амын тоо 2.4 сая байгаагаас 50.4 хувь нь эмэгтэйчүүд юм. Нийт эмэгтэйчүүдийн 46.1 хувь нь 0 - 19 насны охио эзэлж байна.

- Боловсролын салбарт ажиллагсдын 71.1 хувь,
- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт ажиллагсдын 80.3 хувь,
- Худалдаа, үйлчилгээний салбарт ажиллагсдын 54.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Эмэгтэйчүүдийн 97.5 хувь нь бичиг үсэгт тайлагдсан. 2000 оны байдлаар их сургууль, коллежид суралцагсдын 63,2 % нь эмэгтэйчүүд байна.

Хэдийгээр монголын эмэгтэйчүүд ихээхэн амжилтаанд хүрсэн мэт харагдавч зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үйл явц нь эмэгтэйчүүдэд илүү хүндээр туссан юм. Ядуурал, ажилгүйцэл, гэр бүл салалт газар авч, эмэгтэйчүүдийг тойрсон таагүй үзэгдлүүд урган гарч ирсэн юм.



- 2000 оны хүн амын тооллогоор манай улсад нийт өрхийн 16,3 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй байгаагаас 47,1 хувь нь ядуу амьдралтай гэсэн үзүүлэлт гарчээ.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан

Эмэгтэйчүүдийн мэргэн оюун ухаан, хүч чадал, авъяас чадвар нь Монголын нийгмийн хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Шинэчлэл, өөрчлөлтийн их давалгаанд ажил амьдарлынхаа төлөө хүч чадлаа шавхан байж сайн сайханд тэмүүлэн тэмцэж яваа эмэгтэйчүүд, эхчүүдийн нөр их хөдөлмөрийг ухамсарлах нь хүн бүрийн хүндлэх зарчим мөн.

Эрхэм зорилго

Монголын эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн байгууллагуудыг улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдралд идэвхитэй оролцоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тэгш, шударга, ардчилсан нийгмийг байгуулахад хувь нэмрээ оруулахад оршино.

Зорилт

- ☞ Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөний тогтвортой хөгжлийг хангахад туслах,
- ☞ Эмэгтэйчүүдийн хүний эрх, жендерийн тэгш эрхийг баталгаатай хангахад хувь нэмрээ оруулах,
- ☞ Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх,
- ☞ Хөдөөгийн эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг хөгжүүлэхэд туслах,
- ☞ Шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Үйл ажиллагааны үндсэн чиглэл

- ☞ Хөрөнгө босгох
Монголын эмэгтэйчүүдийн санал санаачлагыг дэмжихийн төлөө санхүүгийн нөөцийг хуримтлуулах төрөл бүрийн ажил зохиох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ☞ Санхүүжилт олгох
Эмэгтэйчүүдийн байгууллагуудаас ирүүлсэн төслийг шалгаруулах, сэдэвчилсэн төслийн уралдаан зарлах, хувь хүмүүст гэнэтийн тусламж олгох, жижиг аялалын зардал олгох ажлуудыг хийнэ.
- ☞ Мэдээлэл, сурталчилгаа явуулах
МОНЭС-ийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, энэрэн нигүүлсэнгүй үзэл, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар олон нийтийг гэгээрүүлэх, санхүүжилт авсан

Монголын Эмэгтэйчүүдийн төлөө сан бүрдүүлж тэтгэлэг олгоно эмэгтэйчүүдийн бүлгүүдийн үйл ажиллагааг сурталчилах ажлуудыг зохино.

᠎᠎ Байгууллагын чадавхыг бэхжүүлж хөгжүүлэх
Хүний нөөцийг хөгжүүлэх, материаллаг базыг
бэхжүүлэх, гадаад дотоодын байгууллагуудтай хамтран
ажиллах ажиллагааг өргөжүүлнэ.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан 2002 он

МОНЭС 2002 онд 7.9 сая төгрөгийн сан бүрдүүлж нийт
45 байгууллагаас төслийн санал хүлээж авснаас 21
байгууллага, бүлгүүдэд тэтгэлэг олголоо.

1. Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөний тогтвортой хөгжлийг хангах

1992 оноос Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд
үүсэн байгуулагдсан бөгөөд одоо ХЗДХЯ-нд бүртгэлтэй 70
гаруй, тэдгээрийн орон нутаг дахь салбар нийт 800 гаруй
байгууллага ажиллаж байна.

ЭТББ-дын идэвхитэй үйл ажиллагаа, хүчин чармайлтын үр
дүнд эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийг тойрсон олон
бэрхшээлтэй асуудлууд нааштайгаар шийдвэрлэгдэх үүд
хаалга нээгдсэн ч ихэнх байгууллагууд санхүүгийн
бэрхшээлийн улмаас үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд
хүрч байна. Одоогийн байдлаар 20 гаруй байгууллага л
ажлын байр, ажлын албатай байна. Тэдгээр нь ихэвчлэн
жил бүхэн үнэ нь нэмэгддэг түрээсийн байранд үйл
ажиллагаагаа явуулж байна.

Сангийн зорилт:

ЭТББ-ын

- материаллаг базыг бэхжүүлэх
- Хүний нөөцийг хөгжүүлэх
- Санхүүгийн чадавхыг сайжруулахад хувь нэмрээ оруулах зорилготой.

Энэ хүрээнд дараахи тэтгэлэгийг олголоо.

- Багануур дүүргийн ХЭҮТөвийн зөвлөлийн зөвлөгөө өгөх өрөөний тохижилтын зардалд 200 000 төгрөг
- Эмэгтэйчүүд-Хүүхэд хөгжлийн Эх сан төвийн захиргааны зардалд 250 000 төгрөг олголоо.

2. Эмэгтэйчүүдийн хүний эрх

Монгол улсад 3 эмэгтэй тутмын нэг нь аливаа нэг хүчирхийллийн дор, 10 эмэгтэй тутмын нэг нь бие махбодийн хүчирхийлэлд өртөж байна.

Манай улс эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой Олон улсын таван гэрээнд нэгдэн орсон.

Үндэсний Эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичигт хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй ч эмэгтэйчүүдийг шууд ба шууд бусаар ялгаварлан гадуурхсан хэвээр байна. Эмэгтэйчүүдийн тэгш эрхийн хэрэгжилтийг хянах механизм сул, эмэгтэйчүүдийн эрх зүйн мэдлэг хангалтгүйгээс хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадахгүй хохирох, хохиролыг нөхөн төлөх механизм ч хангалттай бүрдээгүй байна.

Өнөө үед эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нийгмийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Жендерийн ялгаварлалаас үүдсэн хүчирхийлэл нийгмийн харилцааны аль ч хүрээнд тохиолдсоор байна.

Сангийн зорилт:

- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг явуулж буй аливаа үйл ажиллагааг дэмжих
- Эмэгтэйчүүдийн эсрэг чиглэсэн аливаа хүчирхийллийг бууруулах, таслан зогсоохын төлөө үйл ажиллагааг дэмжих
- Эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалах, боолчлохын эсрэг явуулж буй үйл ажиллагааг дэмжих,
- Эмэгтэйчүүдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн санал санаачлагыг дэмжих

Энэ хүрээнд 2002 онд дараахь тэтгэлэгийг олголоо.

- Эмэгтэй удирдагч сангийн ажлын байран дахь бэлгийн дарамтлалын тухай телевизийн нэвтрүүлэг хийх төсөл 500 000 төгрөг /2002 оны 2 сар/
- Эмэгтэй удирдагч сан. Ажлын байрны эсрэг бэлгийн хүчирхийллийн тухай нэвтрүүлгийг орон нутагт түгээх төсөл 285 000 төгрөг /2002 оны 12 сар/
- Багануур дүүргийн ХЭҮТ. Сургуулийн хүүхдүүдэд ажлын байрны бэлгийн дарамтлалын талаар сургалт явуулах төсөл 150 000 төгрөг

- "Глоб интернешнл" ТББ-ын "Дэлхий ертөнц бүсгүйчүүдийн нүдээр" эмэгтэй киночдын Олон Улсын Форумын дугуй ширээний ярилцлагын зардал 300 000 төгрөг



Эмэгтэй киночдын уран бүтээлээр дамжуулан дэлхийн олон орны соёлын харилцааг хөгжүүлэх, кино урлагт эмэгтэй киночдын оруулах хувь нэмрийг дээшлүүлэх, мэргэжилдээ амжилт гаргахад нь туслах зорилготой энэхүү форум нь 2002 оны 9 сарын 16-21-нд УБ-т явагдсан бөгөөд Төв Ази, Кавказ, Европын 8 эмэгтэй киночид оролцсон юм.

3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх,

Нийт ажилгүйчүүдийн 69.5 хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлж байгаагийн дотор 52 хувь нь охид, эмэгтэйчүүд байна.

Шилжилтийн үеийн өмч хувьчлал, бүтцийн өөрчлөлтөөс орон тооны цомхтголд илүү өртсөн эмэгтэйчүүд өөрсдийн боломж бололцооныхоо хирээр ажлын байраа бий болгож бага хэмжээний орлого олж байгаа ч энэ нь амьдралын наад захын хэрэгцээг хангах төдий байна. Олон хүүхэдтэй, ихэвчлэн хотын захын хороололд амьдардаг болон өрх толгойлсон ядуу амьдралтай эмэгтэйчүүд хөдөлмөрийн захаас ажил олж хийх боломж тун бага байна. Үүнд мөн тахир дутуу эмэгтэйчүүд ч хамаарна.

Сангийн зорилт:

- Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой аливаа санал санаачлагыг дэмжин дэлгүүлэхэд туслалцаа үзүүлэх,
- Ядуу эмэгтэйчүүдэд ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх,
- Эмэгтэйчүүдэд шинэ техник, технологийн мэдлэг олгох сургалтанд дэмжлэг үзүүлэх,

- Монголын Эмэгтэйчүүдийн төлөө сан бүрдүүлж тэтгэлэг олгоно
- Эмэгтэйчүүдийн хийсэн бүтээлийг олон улсын тавцанд гаргажид нь дэмжлэг үзүүлэх,

Энэ хүрээнд 2002 онд дараахь тэтгэлэгийг олголоо.

- ЭТББ 3 байгууллагатай хамтран "Гар урлал эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих" төсөлд 812 200 төгрөг олголоо.
- УБ хотын 9/зөвлөлийн караагүй эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах төсөл 150 000 төгрөг
- Эмэгтэйчүүд хүүхэд хөгжлийн Үх сав төсөд гадаадын хөрөнгө оруулалштай хувийн 12 компанид эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд судалгаа явуулах төсөл 215 000 төгрөг



"Гар урлал эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих" төслийн хүрээнд явагдсан үзэсгэлэнд өөрийн эсгийгээр хийсэн "Их Монгол" бүтээлээрээ тэргүүн байранд шалгарсан В. Барангэрэл

Улаанбаатар хотын Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс хэрэгжүүлсэн караагүй эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах төсөлд хамрагдсан "Өөдрөг эхлэл" бүлгийнхэн

4. Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр

Магай орны хөдөөд сүүлийн 3 жилийн турш үргэлжилсэн өвөлийн зүд, зун ган гачиг нь өрх толгойлсон эмэгтэйчүүдэд илүү хүндээр түсч байна.

Магай орны хүн амын 45.1 хувь нь хөдөөд хагас суурин болов нүүдлийн хэзшээр амьдарч байна. Монгол улс 30 гаруй сая малтай бөгөөд хөдөөгийн иргэд мал маллаа түүний ашиг шимээр аж амьдралаа авч явдаг бөгөөд ган, зүд, хүчтэй салхи, галын аюулаас нэг ч малгүй болсон өрхийн тоо жил бүхэн нэмэгдсэнээс суурин газар нүүдэллэн амьдарлаа дээшлүүлэхийг хүсэвч тийм амар ажил олдохгүй бөгөөд ажил олсон эмэгтэйчүүдийн цалин хөлс нь дөнгөж амжиргаа залгах төдий байна.

Хөдөөгийн эмэгтэйчүүд эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах, нийгмийн амьдралд оролцох боломж нөхцөлөөр хязгаарлагдмал алслагдан амьдарч байна.

Сангийн зорилт:

- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хүний эрхийг хангахад чиглэсэн аливаа үйл ажиллагааг дэмжих
- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн бие даасан байдал, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хамтын хөдөлмөр дээр суурилсан аливаа санал санаачлагыг дэмжих
- Шинээр ажлын байр бий болгох саналыг дэмжих
- Ядуу, өрх толгойлсон олон хүүхэдтэй ганц бие эхчүүдийн аж амьдралыг дээшлүүлэхэд туслах
- Хөдөөгийн ЭТББ-ыг чадавхижуулах




Энэ хүрээнд дараах тэтгэлэгийг олголоо.

- Төв аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлд 150 000 төгрөг
- Өмнөговь аймгийн ХЭХДС -ийн "Ингэн сүү" сургагч багш бэлтгэх сургалт 300 000 төгрөг
- МЭХ Говь -Алтай аймгийн Цогт суманд зохион байгуулагдах Бүсийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын зардалд 120 000 төгрөг
- Баянхонгор аймгийн Баянлиг сумын ХЭХДС-д эсгий урлалын төсөл 300 000 төгрөг
- Төв аймгийн Хүчирхийллийн эсрэг Төвд гэр бүлийн хүчирхийллийн талаар шинэ залуу гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалтын зардалд-458 400 төгрөг
- Дархан-Уул аймгийн ХЭХДС-д Орхон сумын 10 эмэгтэйчүүдэд өрхийн орлого нэмэгдүүлэх "Сүү шим" төсөл 300 000 төгрөг

Монголын Эмэгтэйчүүдийн төлөө сан бүрдүүлж тэтгэлэг олгоно

- Увс аймгийн Баруунтуруун сумын Эмэгтэйчүүдийн холбоо ноосон эдлэл үйлдвэрлэх төсөл 300 000 төсөл
- ЛЭОС-ийн Дорнод аймгийн салбар зөвлөл АББХ-ийн эсрэг сурталчилгаа 150 000 төгрөг
- Дархан-Уул аймгийн ХЭҮТ АББХ-ийн эсрэг сурталчилгаа 150 000 төгрөг
- Булган-НИХТ ТББ-д эмэгтэйчүүдийн эрхийн талаар сургалт явуулах 150 000 төгрөг
- Баян-Өлгий аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо АББХ-ийн эсрэг сурталчилгаа 150 000 төгрөг
- Өмнөговь аймгийн НДЭХ-ний салбар зөвлөл АББХ-ийн эсрэг сурталчилгаа 150 000 төгрөг



Говь-Алтай аймгийн Цогт суманд зохион байгуулсан бүсийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт

5. Шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих хөтөлбөр

Парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл 1996 оны сонгуулиар 10.5% байсан бол 2000 оны сонгуулиар 11.8 хувийг эзлэх болов.

Улс орноо удирдахад иргэн бүр оролцох эрхтэйг Үндсэн хуулиар, төрийн албанд зэрэг дэв дэвшихэд эрэгтэй, эмэгтэй хүн тэгш эрх, адил нөхцөл, боломж эдлэхийг Төрийн албаны тухай хуульд баталгаажуулсан байдаг ч хэрэгжилт төдийлөн хангалтгүй, улс төр, шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүдийн оролцоо үлэмж бага байна. Засгийн газрын бүрэлдэхүүнд дэд сайдын албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэй 1 байгаа нь 4.5 хувийг эзэлж байна. Аймаг, нийслэлийн ИТХ-ын бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 12.9% байна. Мөн аймаг, нийслэл, дүүргийн засаг дарга нэг ч эмэгтэй байхгүй

Сангийн зорилт

- Эмэгтэйчүүдийг улс төрийн болон удирдах албан тушаалд бэлтгэх үйл ажиллагааг дэмжих

ЭНЭ АЖИЛЛАГААНЫ ХАРААГ АРСААГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Б. МОНГОЛЫН ДАЛГАВЧИЛУУДИЙН САНХАЙ АРСААГ ҮЙЛ АЖИЛЛАГАА
БЭЭЖЭЭГЭЭС ДООХООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

А. ХУВИЙ АЖИЛЛАГАА

Хувиар ажиллах үйл ажиллагаа болжигорхой, үзвэл
үргэлжлэх, хөгжлөөс хойно үндэст бус түүний хөгжил
гэжжүүлэх, хөгжлөөс хойно бэжжүүлэх явдал юм.

Хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа

Б. ХУВИЙ АЖИЛЛАГАА

Хувиар ажиллах үйл ажиллагааны хувиар ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа

2012 оны ажил ажиллах үйл ажиллагааны хувиар ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа



Хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа
хувиар ажиллах үйл ажиллагаа, түүнийг ажиллах үйл ажиллагаа

Мэдээлэл

Сангийн Тэргүүн Н.Чинчулуун нь Эмэгтэй Удирдагч сангаас Жил бүхэн тодруулдаг "Удирдагч эмэгтэй" өргөмжлөл, тэмдэгээр шагнагдав.

Гарын авлагатай болов.

2002 онд бид сайн дурын гишүүддээ зориулсан "Сайн дурынхан-нийгмийн хөгжилд" гарын авлагыг МННХ-ийн дэмжлэгтэйгээр 500, НҮБ-ийн СДБ-ын дэмжлэгтэйгээр дахин 1000 хувь хувь бэлтгэн гаргасан юм. Энэ гарын авлага нь Сайн дурынхны тухай, дэлхийн сайн дурын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй өгүүлсэн энгийн ном бөгөөд зөвхөн тус сангийн сайн дурын ажилтнуудад ч биш, ер нь аль ч байгууллагад ажиллах сайн дурын ажилтанд гарын авлага байхад зориулагдсан билээ

Орон нутгийн сайн дурынхан

Орон нутагт сайн дурын төлөөлөлтэй болох нь бидний энэ оны өмнөө тавьсан зорилтуудын нэг байв. Ховд, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Орхон, Дархан-Уул аймгаас сонгогдож ирсэн 7 эмэгтэйг сайн дурын сургалтанд хамруулснаар дээрх аймгуудад МОНЭС-ийн үйл ажиллагааг сурталчлах, тэтгэлэг авагч бүлгүүдтэй ажиллах төлөөлөлтэй болсон ба сангийн үйл ажиллагааг өргөжүүлж нийт орон даяар явуулах эх үүсвэр тавигдсан гэж үзэж байна.

Бусад үйл ажиллагаа

Сургалт

МОНЭС нь дэргэдээ 20 хүний суудалтай сургалтын танхимтай бөгөөд дараах түвшний сургалтыг явуулдаг.

- ❖ Байгууллагын хүний нөөцийг бэхжүүлэх, хөрөнгө босгохтой холбогдуулсан Удирдах зөвлөл, гүйцэтгэх алба, хандивлагч, сайн дурын гишүүдийн сургалт
- ❖ ЭТББ-уудын бүтэц, зохион байгуулалт, санхүү, бүртгэлийн асуудал, менежментийн холбогдолтой сургалт
- ❖ Амьдрах ухаан- гэрийн эзэгтэй нарт зориулсан төрөл бүрийн бичил сургалтууд

Тус төвийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу сайн дурын ажилтан, удирдах зөвлөлийн гишүүн, эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын ажилтнууд, хандивлагч нарт, гүйцэтгэх албаныханд зориулсан сургалтуудыг удаа дараа хийлээ. Эмэгтэйчүүдийн хүний эрх, жендерийн асуудал, энэрэн нигүүлсэх үзлийн тухай, бусдын тусын тулд өөрийгөө хэрхэн зарцуулах тухай, мөн ЭТББ-ын менежмент, чадавхийг бэхжүүлэх талаар хичээл явуулдаг юм. Эмэгтэйчүүдэд өрхийн орлогоо нэмэгдүүлэх, ахуйн хэрэгцээгээ хангахад нь туслах зорилгоор "Адра" сангаас жил бүр тараадаг хүнсний ногооны үрийг тус сангийн байрладаг дүүргийн өрх толгойлсон 20 эмэгтэйд тарааж, тэдэнд хүнсний ногоог гэрийн нөхцөлд хэрхэн тарих талаар мэргэжлийн багшаар сургалт явуулсан. Мөн бусад орнуудын хүнсний ногоог даршладаг аргууд, хоол хийх уламжлалт аргуудтай танилцуулах, сургах сургалтыг удаа дараа хийлээ.

Судалгаа

Манай оронд сан бүрдүүлэх, хандив цуглуулах нь шинэлэг, нийтийн хүртээл болоогүй ойлголт билээ. Хүмүүсийн ойлголтгүй байгаа байдал нь хандив цуглуулах ажиллагаанд бэрхшээл учруулдаг учраас цаашдын үйл ажиллагаандаа юут анхаарвал зохих, олон нийттэй хэрхэн ажиллах, хандив өргөдөг хүслийг тодруулах зорилгоор Улаанбаатар хотын хэмжээнд 153 хүнийг хамруулсан бичил социологийн судалгаа хийсэн юм. Судалгаанд хамрагсадын 67.3 хувь нь эмэгтэйчүүдэд тусламж дэмжлэг үзүүлэхэд бэлэн гэж хариулсан байна. Харин ямар хэлбэрээр туслах вэ гэсэн асуултанд сэтгэл санааны тусламж үзүүлнэ гэсэн нь 43.8 хувь, тусламж үзүүлж чадах байгууллага, удирдах хүмүүстэй холбож өгнө гэсэн нь 25.7 хувь, эд материалын тусламж үзүүлнэ гэсэн нь 15.7 хувь байхад хамгийн бага хувь буюу 14.7 хувь нь мөнгөн тусламж буюу хандив өгнө гэсэн байна. Үүнийг өнөөгийн монголын хөгжлийн түвшин, эдийн засгийн байдал, шилжилтийн үйл явцтай холбон тайлбарлаж болох юм. Энэхүү судалгаа нь сурталчилгаа, мэдээллийн чиглэлийн үйл ажиллагаанд түлхүү анхаарах ёстойг харууллаа.

Гадаад харилцаа

Дэлхийг өөрчлөх филантропи хөдөлгөөнийг дэмжиж мөр зэрэгцэн хамтран ажиллах сайхан боломж бидэнд тохиож Олон улсын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ, "Хил хязгааргүй тэтгэлэг олгогч" сүлжээний гишүүн болсон нь сангийн цаашдын үйл ажиллагаанд асар их боломжийг нээн өгсөн билээ.

2002 оны 1 сард Энэтхэг улсын Хайдарбад хотод болсон ОУЭСС-ний III уулзалтанд тус сангийн Тэргүүн Н. Чинчулуун, гүйцэтгэх захирал Д. Пүрэвсүрэн, гадаад харилцааны

Монголын Эмэгтэйчүүдийн Сан-ын бүрдүүлж гаргасан улсын зохицуулагч В. Нандинчимэг нар, АНУ-ийн Вашингтон хотод болсон "Хил хязгааргүй тэтгэлэг олгогч" сүлжээний ахуйтвар чуулганд гүйцэтгэх захирал Д. Пүрэвсүрэн оролцож тэтгэлэг олгогч сангуудын үйл ажиллагаатай танилцах, шинийг мэдэх, цаашдын үйл ажиллагаагаа нэг цат ахиулах бодит боломжийг бүрдүүлэв. Мөн эгч дүүс Непалийн Теза сан, Гонк Гонгийн Эмэгтэйчүүдийн Сангийн төлөөлөгчид тус санд айлчлах сангийн үйл ажиллагаатай танилцах, санал сэтгэгдлээ солилцлоо.

Хандивлагчид

Аашиймаа	Батбуян Ц.	Доржханд Х.	Нарангэрэл Н.
Азжаргал Б.	Батсайхан Д.	Долгосүрэн Д.	Нарантунгалаг Д.
Ариунчимэг Г.	Батхишиг	Дондов С.	Нарантуяа
Ариунаа Г.	Баттуяа	Дуламжав Д.	Нандинчимэг Б.
Ариунаа П.	Батцэцэг Б.	Дуламсүрэн	Намуун Э.
Ариунжаргал Н.	Бат-эрдэнэ Б.	Дөлгөөн Э.	Нина Б.
Ариунзул Д.	Бат-эрдэнэ Ч.	Дунжаа Г.	Нямсүрэн
Ариунтуяа	Баяраа Д.	Дэлгэр	Нямдэлэг
Алимаа	Баяраа С.	Дэлгэрмаа Б.	Одончимэг
Алиманцэцэг Ж.	Баярмаа Б.	Жагдагтармаа Д.	Оргилмаа Д.
Алтантүлхүүр Р.	Баярцогт Б.	Жаргал Б.	Олонбаяс
Алтантуяа Р.	Баясгалан	Жаргал Ц.	Отгон Д.
Алтантуяа Ш.	Билэгсайхан Н.	Жаргал Т.	Отгонжаргал С.
Алтанцэцэг Б.	Биндэрьяа	Жаргалмаа М.	Оюунаа
Алтанцэцэг О.	Болдбаатар С.	Жанчив Р.	Оюунзул Н.
Амгалан Д.	Болдмаа И.	Жанчив П.	Оюунсан
Амаржаргал Д.	Болор	Загдсүрэн	Оюунханд
Амраа Д.	Болормаа М.	Зина	Оюунцэцэг Ч.
Анхгэрэл	Бурмаа	Зориг	Оюунцэцэг Х.
Анхныбаяр Б.	Булган	Ичинноров	Оюун-Эрдэнэ
Аюурзана Ч.	Бундхорол	Ичинхорлоо Т.	Элзийтхагва
Бадам Г.	Буяндэлгэр Ж.	Итгэл	Элзийтбат Б.
Бадамсүрэн Н.	Бяцхандаа Ж.	Лхагважав М.	Элзийтжаргал
Баасанжаргал Г.	Ганчулуун Г.	Лхагвасүрэн Д.	Элзийтгэрэл
Баатархүү Г.	Ганбаатар Н.	Менгөнчимэг	Элзийтбямба Н.
Базарханд Г.	Ганзул П.	Мөнхчимэг	Элзийтүрээ
Барс Н.	Ганцэцэг Б.	Мөнхчулуун Г.	Элзийням
Байгальмаа Г.	Гончигсум Н.	Мөнхбат Ч.	Элзийтсайхан С.
Байгальмаа М.	Гэрэл	Мөнххертэнц Ц.	Өнөржаргал
Байгальмаа Х.	Гэрэлмаа Ч.	Мөнхгэрэл Н.	Өсөхцэцэг Д.
Балжинням Д.	Гэрэлсүрэн	Мөнх-Оргил Т.	Пүрэв Я.
Балжинням Ж.	Гэрэлтуяа Я.	Мөнхтуул	Пүрэвэрэнчин Б.
Батбаясгалан Б.	Даланжин Ж.	Мөнхцэцэг Б.	Пүрэвсүрэн Д.
Бат-Амгалан Б.	Дамдиндорж	Мөнхцэцэг Н.	Пак Чел Сун
Батдорж	Дашням	Мэндсайхан	Рагчаа
Доржсан	Наранчимэг	Раднаа С.	Равжир Р.

Сүрэнбаяр Д.	Цацрал	Хандсүрэн С.
Сүрэнхорлоо Ш.	Цогзолмаа	Хишгээ
Сүндэрмаа	Цогоо Г.	Шүрхүү Н.
Саран С.	Цэендолгор О.	Нийтэл Н
Саруулмонгол	Цэвэлмаа Н.	Эрдэнэ-очир Ч.
Сайжрах Б.	Цэрэнжаргал С.	Эрдэнэцэцэг Б.
Сайнбаяр	Цэрэндорж С.	Эрхэмсайхан Р.
Сайоз Г.	Цэрэндулам	Энхбаатар
Сайнзаяа Д.	Цэрэнлхам С.	Энхжаргал Д.
Сайнзаяа Н.	Цэрэнпүрэв С.	Энхжаргал С.
Сийлэгмаа Ц.	Цэрэннадмид	Энх-Амгалан
Содном Ё.	Цэнд Д.	Энхсайхан
Сувдаа Б.	Цэнд С.	Энхтайван
Сэрчмаа Т.	Цэнд-Аюуш	Энхтунгалаг Г.
Сэргэлэн Т.	Цэндсүрэн	Энхтуяа Р.
Сэлэнгэ	Цэмбэлмаа	Энхтуяа Т.
Сэмжидмаа Д.	Цэцэгмаа Ш.	Энхцэцэг Н.
Туваандорж И.	Цэцэгээ О.	Ямаахай С.
Төгсөө Б.	Цэцэгээ Х.	Янжмаа Б.
Туул Л.	Чинчулуун Н.	
Туяа Ч.	Чимгээ	
Туяахүү Д.	Чинзориг	
Туяацэцэг Ч.	Чимидцэрэн Ё.	
Тэмүүжин Д.	Чимэдбадам И.	
Уранчимэг Б.	Чулуунцэцэг	
Уранбилэг Ч.	Чуулган	
Урантогоо	Хажидсүрэн С.	
Урьхан Э.	Хандмаа	
Ундрах Ч.	← Хандсүрэн Л.	
Ундрахсайхан		

Хандивлагч байгууллага

- АС Пресс хэвлэлийн газар
- "Азийн хөгжлийн сан" ХЗХ
- "Батбайгаль" ХХК
- "Уран гар" ХХК
- Сантис сан
- Эрдэнэ суврага ХХК
- ХЭХДС
- Төв аймгийн Э/зөвлөл

Хандивлагч гадаадын иргэд

- | | | |
|----------------------------|-----------------------|---------------------|
| - Ким С. Хантер | - Давид | - Ахмед Зиаунддин |
| - Чо Юү Сан | - Жон/Мирна Коваллисс | - Эвелин Б. Серрано |
| - Чикаго Сангийн төлөөлөгч | | |

Монголын Эмэгтэйчүүдийн төлөө сан бүрдүүлж тэтгэлэг олгоно
Мөн тус сангаас зохион байгуулсан хөрөнгө босгох үдэшлэг,
соёлын арга хэмжээнүүдэд удаа дараа өөрийн цаг зав, авъяас
чадвар, хөдөлмөрөө хандивлан оролцсон, сайн дурын сургалт,
амьдрах ухааны сургалтуудад үнэгүй хичээл заасан дараах
хүмүүст талархал илэрхийлье.

- | | |
|-----------------------------------|----------------|
| * СТА Дуучин Дэжидмаа | Д. Амаржаргал |
| * Дуучин, хөгжимчин Д. Баярмагнай | Б. Нандинцэцэг |
| * Л. Арзунчимэг | Л. Сүрэнбаяр |
| * Цой Эмира | Г. Ганчулуун |
| * Ким Евгения Николаевна | |

2001 онд олгосон тэтгэлэгийн үр дүнгээс

1. Эмэгтэйчүүдийн хүний эрхийн чиглэлээр:

* Ахмадууд нийгэмлэг" Сайн дурын ажилтнууд бэлтгэх сургалтын төсөл

Төслийн хүрээнд 25 ахмадыг хамруулсан сайн дурын ажилтан бэлтгэх сургалт явуулж, тус тусын оршин суугаа газрын орон гэрээсээ гарах чадваргүй 250 гаруй ахмадуудад гэрт нь очиж сэтгэлийн дэм үзүүлэх, мөн өрхийн эмчийн үйлчилгээг ойртлуулах ажил хийлээ.

* Эмэгтэй удирдагч сан "Ажлын байран дахь бэлгийн хүчирхийлэл" төсөл

Ажлын байран дахь бэлгийн хүчирхийллийн эсрэг "Эмэгтэйчүүд-Эрх чөлөө" 3 сарын аяныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан энэ хүрээнд хэвлэлийн бага хурал хийлгэж, Өнөөдөр сонинд уриалга, MN болон Ийгл телевиз, FM 104.5, Монголын радиогийн "Гурван эрдэнэ" студэд ярилцлага явуулж, "Жендэр ба тэгш эрх" гарын авлага бэлтгэн гаргаж их дээд сургуулиуд, эмэгтэйчүүд, албан байгууллагууд, иргэдэд тараах, цуврал гарын авлага, судалгаа авах зэрэг ажлуудыг хийжээ. Ийгл телевизээр АБДБХ-ийн тухай "Хаалганы цаана" 50 минутын нэвтрүүлэг хийж элчин сайд, УИХ-ын гишүүн, гадаадын мэргэжилтнүүд, компанийн удирдлагуудыг оролцуулсан нь маш их үр дүнтэй боллоо.

* ХЭҮТ Хүүхэд хамгаалах нэгж "Хүүхдэд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг боловсронгуй болгох нь" төсөл

Хүүхэд хамгаалах нэгж нь хүчирхийлэл дарамтанд өртсөн хүүхдүүдтэй ажиллаж тэднийг нөхөн сэргээх, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг. Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд олон хүний өмнө өөрийн асуудлаа ярьж чаддаггүй учир болсон явдлын талаар баримтыг цаг тухайд нь хүүхдээр яриулж баримт материалыг бүрдүүлэх үүднээс хүүхдэд зөвлөгөө өгөх бүртгэлийн программд зориулсан камер микрофоны зардлыг МОНЭС олгосон. Төслийн хугацаанд 0-18 насны /давхардсан

Монголын Эмэгтэйчүүдийн төлөө сан бүрдүүлж тэтгэлэг олгоно
тоогоор/ 100 гаруй хүүхдэд шаардлагатай зөвлөгөө тусламжийг
гзүүлсэн

* ТДЭМ "Ажлын байран дахь бэлгийн хүчирхийлэл" төсөл
Налайх, Дархан, Дорноговь аймаг, 29-р сургуульд нийт 200
гаруй хүнд хууль эрх зүй, хүчирхийллийн сэдвээр сургалт
явуулсан. Ялангуяа өсвөр насны тахир дутуу охид бэлгийн
хүчирхийлэл өртөх байгааг харгалзан биеэ хамгаалах арга
ажиллагааны тухай зааж сургажээ. Монгол ТВ-ийн нийгэм соёлын
редакцитай хамтран 3 сард телевизийн нэвтрүүлэг хийж, тахир
дутуу хүнд ойлгогдох энгийн хэлээр бичигдсэн гарын авлага
хэвлэгдсэн.

*ЭТББ-ын эвсэл Нэр дэвшигчд эмэгтэйчүүдэд зориулсан гарын
авлага хийх төсөл

Сонгуульд оролцох болсон шалтгаан, сонгуультай холбоотой
дүрэм журам, компанит ажлын зохион байгуулалт, тойргийн
судалгаа, багаа бүрдүүлэх, төсвөө хэрхэн тооцоолох, мөрийн
хөтөлбөр боловсруурах, сурталчилгаа, сонгогчидтай уулзалт
хийх, имидж бүрдүүлэх, өнөөгийн эмэгтэйчүүдийн улс төрийн
байдал зэрэг асуудлаар нэр дэвшигч эмэгтэйчүүдэд зориулсан
гарын авлага бэлтгэгдэн гарлаа.

2. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулах чиглэлээр:

* Дундговь, Сайхан-Овоо сум "Шахмал түлш" төсөл

Сумын ажилгүй, нэн ядуу, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг ажлын
байраар хангах зорилготой энэ төсөл хэрэгжсэнээр өрх
толгойлсон 3 эмэгтэй, нэн ядуу амьдралтай 3 өрх, нийт 9 хүн
ажлын байртай болж 16200 ш шахмал түлш хийн борлуулж ажлын
цалин, цаашид амьдралын байнгын эх үүсвэртэй боллоо.

*Багануур дүүрэг, ЭТББ-ын эвсэл "Гэгээ" төсөл

Хиам үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж авч жижиг цех ажиллуулан
нийт 4 эмэгтэй ажлын байртай болсон.

* Ахмадууд нийгэмлэг" "Хуучныг шинэчлэе"

Эмэгтэйчүүд өөрсдийн нөөц бололцоог ашиглан хэнд ч байдаг
хуучирсан хувцсаар шинэлэг загварын хувцас хийх сургалтанд
зориулж Японы сэтгүүлээс 2500 ширхэг загвар хувилж гэрийн
эзэгтэй нарт тараасан .

*ХЭХДС-ийн Дархан Уул аймгийн СЗ "Сүү шим" төсөл

МУ-ын ЗГ-ийн "Цагаан хувьсгал" хөтөлбөрт нийцүүлэн
хэрэгжүүлж буй сургалтын энэ төсөлд Дархан-Уул аймгийн
Шарин гол сумын хөдөлмөр эрхлээгүй, өрх толгойлсон эхчүүд,
малчид, албан хаагчид зэрэг 13 эмэгтэй хамрагдаж сүү
цагаан идээг орчин үеийн технологиор боловсруулах аргад
суралцаж, цаашид өрхийн амьжиргааг дээшлүүлэх, орлогын эх
үүсвэртэй болох, хаягдал шар сүү болон хоёрдогч түүхий эдийг
ашиглан төрөл бүрийн бүтээгдэхүүн боловсруулж хүнсэндээ

Монголын Эмэгтэйчүүдийн төлөө сан бүрдүүлж тэтгэлэг олгоно хэрэглэж хэвшихэд суралцсан байна. Сургалтанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч Л. Пүрэвдаш нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг өргөтгөн сүү цагаан идээний жижиг цех байгууллан ажиллаж эхлээд байгаа ба сургалтанд хамрагдсан ажилгүй 2 эмэгтэйг ажилд элсүүлж, ажлын байртай болголоо.

3. ЭТББ-ыг чадавхийг бэхжүүлэх чиглэлээр:

* МЭТББ-ын Сүлжээ

Байгууллагын чадавхийг дэмжих төсөл

ЭТББ-ын ҮС-ний үйл ажиллагаа тогтмолжих, эмэгтэйчүүдийн дүү хоолоыг төрийн өндөрлөгт хүргэх ажилд тодорхой хувь нэмэр оруулсан.

*Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт төв

Албан бус секторт хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн нөхцөл байдлын судалгаа гаргах, монголын уламжлалт гар урлалын бүтээгдэхүүнийг сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр голлон ажилласан.